

Согтууруулах ундааны үйлдвэрлэл болон тамхи импортлох тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгаж үнэлэлт дүгнэлт гаргах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2007 оны 84 дүгээр тогтоол, 2013 оны 191 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2004 оны 58 дугаар тушаалыг үндэслэн согтууруулах ундаа болон тамхины үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, тэдгээрийн үйлдвэрлэл болон тамхины импортын үйл ажиллагаанд тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хяналт тавин ажилладаг.

Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх, импортлох тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тус тус сунгадаг.

Аж ахуйн нэгж байгууллагууд нь дараахи материалуудыг бүрдүүлж ажлын хэсэгт бүрдүүлж өгнө.

1. Хүсэлт гаргасан албан бичиг
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
3. Улсын бүртгэлийн гэрчилгээ
4. Тохирлын гэрчилгээ
5. Улсын болон нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн ажлын байрны болон бүтээгдэхүүний эрүүл ахуйн дүгнэлт
6. Татварын газрын тодорхойлолт
7. Галын аюулгүй байдлын дүгнэлт

Тамхи импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч нь дээрх материалыг бүрдүүлэхээс гадна дараах материалыг бүрдүүлж өгнө.

8. Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн
9. Гаалийн төв лабораторийн дүгнэлт
10. Бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах талаар экспортлогч орны үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээний хуулбар;

Ажлын хэсэг нь дээрх материалуудыг бүрдүүлж дүгнэлт гарган Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад материалыг хүргүүлдэг. Хүнсний асуудал эрхэлсэн төв байгууллагаас тусгай зөвшөөрлийг шинээр олгох болон сунгах, үйл ажиллагааг зогсоох зэрэг асуудлыг шийдвэрлэдэг.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, согтууруулах ундааны үйлдвэрлэл болон тамхины импортын үйл ажиллагаа, техник технологи, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг шалгасан акт болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын саналыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн, шийдвэрлүүлдэг.